



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/НЗ

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.7, 4.7.6, 7.4.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны Сургалтын хяналтын тоо, зардал батлах" тухай 188 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх нь" сургалтын удирдамжийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтын дагуу төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг танилцуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг /Ч.Баттулгад/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



420510

**"ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД БЭЛТГЭХ НЬ"
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Үндэслэл: Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн байгууллагуудад чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах, зөвлөн туслах, магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангуулах чиглэлээр сургалт зохион байгуулах зэрэг чиг үүргийнхээ хүрээнд эрүүл мэндийн салбарын хэмжээнд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, чанарын алба болон багийн ахлагч, гишүүд, чанарын менежер, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байранд нь тасралтгүй суралцах боломж бүрдүүлэх шаардлагатай байна.

Зорилго: Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаархи мэдээлэл, арга зүйгээр ханган, ажлын байранд нь зайн сургалтанд хамруулж, тасралтгүй чадавхижуулахад оршино.

Зорилт:

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаархи мэдээлэлээр ханган, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээ хийх мэдлэгийг дээшлүүлэх, арга, аргачлалаар хангах, шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх;
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, эмнэл зүйн эрсдлийг тодорхойлох, үнэлэх мэдлэг, ур чадварыг сайжруулах, хэрэгжилтэд үнэлгээ хийх арга зүйгээр хангах;

Хамрагдах хүрээ: Аймаг, нийслэлийн улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, чанарын алба болон багийн ахлагч, гишүүд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нийт 60 хүн (30 хүн, 2 удаа) хамрагдана.

Сургалтын арга зүй: Сургалт нь цахим технологийг ашиглан интернет сүлжээгээр зайнаас болон танхимд онолын хичээл явагдана.

Сургалт зохион байгуулагдах газар: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим зайн сургалтын танхимд зохион байгуулагдана.

Сургалт зохион байгуулагдах хугацаа: Сургалт нь 2017 оны 7 дугаар сард зохион байгуулагдана.

Сургалтын багц цаг: Сургалтанд хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалтын бүртгэл, тухайн сургалтын сэдвийн агуулга, багтаамж, цагийг харгалзан багц цаг олгогдох болно.

Сургалт удирдах бүрэлдэхүүн: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Чанар, магадлан итгэмжлэлийн албаны хамт олон, магадлан итгэмжлэлийн шинжээчид, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ТББ-ын мэргэжилтнүүд сургалтыг удирдан явуулна.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлийн бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг зайн цахим сургалтаар ажлын байранд тасралтгүй сургахад оршино.

ЭМХТ-ийн Ерөнхий Захирлын 2017 оны 07 дугаар сарын 28 өдрийн А/143 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт.

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД БЭЛТГЭХ НЬ”
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Цаг	Хичээлийн сэдэв	Багшийн нэр	Сургалтын хэлбэр	Хугацаа (мин)
Эхний өдрийн сургалт: “ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД БЭЛТГЭХ НЬ”				
09.00–09.30	Сургалтын бүртгэл, нээлт, танилцуулга	Зохион байгуулагчид		30
09.30-10.15	Сэдэв: Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны шинэчлэл, өөрчлөлт	ЭМЯ	Лекц	45
10.15-11.00	Сэдэв: Нийслэл, орон нутагт магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах нь	ЭМЯ	Лекц	45
11.00-11.15	<i>Цайны завсарлага</i>		Зохион байгуулагч	15
11.15–12.00	Сэдэв: “Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат, бэлтгэл хангах, хүсэлт гаргах, материал бүрдүүлэлт”	ЧМИА	Лекц	45
12.00–12.45	Сэдэв: Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх нь	ЧМИА	Семинар	45
12.45-13.00	<i>Асуулт, хариулт</i>			15
13.00-14.00	<i>Үдийн завсарлага</i>			60
14.00-14.45	Сэдэв: Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үнэлгээ хийх, үнэлэх аргачлал	ЧМИА	Лекц	45
14.45-15.30	Өөрийн үнэлгээний тайлан бичихэд гарч буй бэрхшээл, анхаарах зүйлс	ЧМИА	Дадлага	45
15.30-15.45	<i>Цайны завсарлага</i>			15
15.45-16.30	Сэдэв: Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, тайлан бичих	ЧМИА	Семинар	45
16.30-17.15		ЧМИА	Лекц	45
17.15-17.30	Сургалтын эхний өдрийн сэтгэгдэл			15
Хоёр дахь өдрийн сургалт: “ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР”				
09.00-09.15	Сургалтын эхний өдрийн сэтгэгдэл танилцуулах	Зохион байгуулагчид	Зохион байгуулагч	15

09.15-10.00	Сэдэв: Тусламж, үйлчилгээний чанар	ЧМИА	Лекц	45
10.00-10.45	Сэдэв: “Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг үр дүнтэй авах, дүгнэлт хийж, ажиллах, эргэн мэдээлэх”	ЧМИА	Дадлага	45
10.45-11.00	<i>Цайны завсарлага</i>			15
11.00–11.45	Сэдэв: “Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах арга хэрэгсэл, шинэ арга, технологи нэвтрүүлэх нь”	ЧМИА	Лекц	45
11.45-12.30	Сэдэв: “Тусламж, үйлчилгээний чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээ”	ЧМИА	Лекц	45
12.30-12.45	<i>Асуулт, хариулт</i>			15
12.45-14.00	<i>Үдийн завсарлага</i>			60
14.00-14.45	Сэдэв: “Эрүүл мэндийн байгууллагын эрсдлийн үнэлгээ хийх арга зүй”	ЧМИА	Лекц	45
14.45-15.30		ЧМИА	Дадлага	45
15.30-15.45	<i>Цайны завсарлага</i>			15
15.45-16.30	Сэдэв: Тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүдэд дүгнэлт хийх нь	ЧМИА	Семинар	45
16.30-17.15		ЧМИА	Дадлага	45
17.15-17.30	<i>Сургалтын 2 дах өдрийн сэтгэгдэл</i>			15

Гуравдах өдрийн сургалт:

“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛЭХ НЬ”

09.00-09.15	Сургалтын эхний өдрийн сэтгэгдэл танилцуулах	Зохион байгуулагчид		15
09.15-10.00	Сэдэв: “Удирдлага, бүтэц, зохион байгуулалт”	ЧМИА	Лекц	45
10.00-10.45	Сэдэв: “Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн бэлэн байдал, эрэмбэлэн ангилалт”	Шинжээч	Дадлага	45
10.45-11.00	<i>Цайны завсарлага</i>			15
11.00–11.45	Сэдэв: Сувилахуйн тусламж, үйлчилгээ, Уламжлалт, сэргээн засах тусламж үйлчилгээ, Нүд, чих хамар хоолой, сэтгэц, хавдрын тусламж үйлчилгээ”	Шинжээч	Семинар	45
11.45-12.30	Сэдэв: “Мэс засал, эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ”	Шинжээч	Лекц	45
12.30-12.45	<i>Асуулт, хариулт</i>			15
12.45-14.00	<i>Өдрийн завсарлага</i>			60

14.00-14.45	“Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр үнэлэх нь: Сэдэв: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ” /халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, тандалт судалгаа хийж, үр дүнг тооцох, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа хэрхэн хийх/	Шинжээч	Семинар	45
14.45-15.30		Шинжээч	Дадлага	45
15.30-15.45	Цайны завсарлага			15
15.45-16.30	Сэдэв: “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр үнэлэх нь: Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, техникийн үйлчилгээ”	Шинжээч	Семинар	45
16.30-17.15		Шинжээч	Дадлага	45
17.15-17.30	Сургалтын талаархи нэгдсэн дүгнэлт ярилцлага	Зохион байгуулагчид		15
17.30-17.45	Сургалтын хаалт, гэрчилгээ олгох үйл ажиллагаа			15

Тайлбар: Сургалтын цагийг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан жишгийн дагуу сургалтын 1 цагийг 45 минутаар тооцов.

ЭМХТ-ийн Ерөнхий Захирлын 2017 оны
дугаар сарын өдрийн дугаар
тушаалын гуравдугаар хавсралт.

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛД БЭЛТГЭХ НЬ”
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

Сургалтын төсвийг Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын зардлын жишгийг баримтлав.

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зардлын жишиг	Нийт зардал/төг/
1	Хичээл заасан багшийн ажлын хөлс	цаг	24*2 удаа	20,000	960,000
2	Зохион байгуулагчийн ажлын хөлс	Хүн/өдөр	2/6 өдөр	10,000	120,000
3	Туслахын ажлын хөлс	Хүн/өдөр	2/6 өдөр	6000	72,000
4	Оролцогчдын бичиг хэргийн зардал	хүн	60	2500	150,000
5	Оролцогчдын хоолны зардал	Хүн/өдөр	60/3	15,000	2,700,000
5	Оролцогчдын цайны зардал	Хүн/өдөр	60/3 өдөр	2000	360,000
6	Материал олшруулах	нүүр	8000	50	400,000
7	Гэрчилгээ хэвлүүлэх зардал	ширхэг	60	1500	90,000
8	Сургалтын бусад зардал/хаяг, самбарын үзэг, бичгийн цаас, хавчаар, утасны зардал гм/				500,000
	Нийт				5,352,000₮

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Д.ГАНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
ЧМИА-НЫ ДАРГА

Н.НАРАНГЭРЭЛ